



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/179

Сангиндалай

Байгалийн гамшигт үзэгдлийн үед хариу арга хэмжээ авах, цахилгаан эх үүсвэр гаргах генератор нийлүүлэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд байгалийн гамшигт үзэгдлийн үед хариу арга хэмжээ авах, цахилгаан эх үүсвэр нийлүүлэх ажлыг иргэн (Б.Бадмаараг)-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Уг ажилтай холбогдон гарах зардал 20,000,000 (хорин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



482302157